

УДК 39(517)

## ЦАХАР НЭРИЙН УЧИР ХИЙГЭЭД ТЭДНИЙ ГЭРИЙН ЕРӨӨЛИЙН ОНЦЛОГ

Соёлцээн (SUYILASIQIN)

МУИС-ийн Улаанбаатар сургуулийн докторант, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө  
Засах Орны Хөххотын үндэстний дээд сургуулийн багш  
E-mail: Sylsq0825@163.com

### Хураангуй

Даяарчлалын давалгаа эрч хүчээ авсан 21-р зуунд улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, оюуны амьдралд асар том өөрчлөлт гарч, ялангуяа нүүдлийн соёлын нийгмийн экологи буюу гадаад орчин өөрчлөгдөн хувьсч, уламжлал шинэчлэлийн харилцан шүтэлцээ алдагдаж, монголчуудын уламжлалт зан үйл мартагдах хандлагатай болж байна. Энэ бол хэрэг дээрээ уг соёлын орших эс оршихын асуудал болж байна. Иймээс монгол соёлын зан үйлийн бүрэн бүтэн цутгалан, нийлбэр, цогцолбор болсон хуримын зан үйлийг анхааралтай судалж, өнөөгийн амьдралд нийцэх ашиг тустай дэвшилттэй ёс заншлыг сурталчилах, дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад бага балчраас нь эзэмшүүлэх арга ухааныг шинэ нөхцөлд тохируулан боловсруулах шаардлагатай байна. Тэр тусмаа ураг хуримын зан үйл, үйлдэл, уг бүрийн цаана ирээдүйн сайн сайхныг бэлгэдэн ерөөсөн, төр улсын үндэс суурь болсон гэр бүлийн бат бэх, тогтвортой байх утга учрыг ухааруулан ойлгуулсан, үүрэг хариуцлагыг мэдрүүлсэн утга төгөлдөр ёс ёслол учраас тусгайлан судлаж, цахар угсаатны хуримын аман яруу найргийн төрөл зүйл хэрхэн уламжилж өнөө цагт яаж хувирч өөрчлөгдсөн, өөрчлөгдөх болсон учир шалтгаан, хүчин зүйлийг гэрийн ерөөлөөр жишээлэн авч энэхүү өгүүлэлд авч үзлээ.

### Түлхүүр үг

Цахар монголчууд, хуримлах ёс, хуримын ерөөл.

UDC 39(517)

## WHO ARE THE TSAHARS AND THE PECULIARITIES OF GOOD WISHES FOR THE YURT

---

**Soyoltsetsen (SUYILASIQIN)**

PhD student at National University of Mongolia, Ulaanbaatar, teacher at Hohhot National Institute of Inner Mongolia Autonomous Region, China

Email: Sylsq0825@163.com

### Annotation

---

In the 21st century, when the wave of globalization gained momentum, there were huge changes in the social, political, economic and intellectual life of the country, especially the social ecology of the nomadic culture or the external environment changed and evolved, the mutual respect for tradition and innovation was lost, and the traditional behavior of Mongols tended to be forgotten. This is actually a question of the existence or non-existence of the culture. Therefore, it is necessary to carefully study wedding rituals, which are a complete complex of Mongolian cultural rituals, and to develop methods for promoting and popularizing useful and advanced customs that are compatible with today's life, and for children and youth to master them from an early age. In particular, it is a meaningful ceremony that symbolizes the good future of the family, which is the foundation of the state, and makes people understand the meaning of the family, and makes them feel the responsibility. The wedding ceremony of the Tzahar ethnic group is specially studied. It is interesting how the genre of poetry has been passed down and how it has changed in the present day. The reasons and factors that led to change have been discussed in this article on the example of home blessing.

### Key words

---

Tzahar Mongols, wedding rituals, home blessings.

## О Р Ш И Л

Монголын ард түмний үндэстний соёлд юу нь шинэчлэгдэж, юу нь уламжлагдаж, тэдгээрийн тэнцвэрт харилцаа хэрхэн хангагдаж байгааг задлан шинжлэх нь эх орны соёл судлалын нэг чухал зорилт болж байна. Энэ асуудлыг түүх, гүн ухаан, соёл, урлаг судлал, нийгмийн бусад салбар ухаан тус тусын чиглэлээр ултай сайн судлан шинжлэх явдал зөвхөн онол, шинжлэх ухааны төдийгүй, төрийн бодлого, үндэстний оршин тогтнохуй хийгээд нийгмийн хөгжлийн хүчирхэг хурдасгуур болсон соёлыг цаашид зөв голдирлоор нь хөгжүүлэхэд үлэмж ач холбогдолтой гэсэн эрдэмтэн Б. Сумъяагийн тодорхойлолт монгол соёлын тухайд улам илүү шаардагдаж байгаа чухал асуудал болох юм (Монголын..., 1998: 4).

Цахар монголчууд бол маш эрт цагт түүхийн тавцан дээр бие даан гарч ирсэн гүн холын сурвалжтай томоохон монгол аймгийн нэг юм. Цахар аймгийн бүрэлдэхүүнд нийт 179 овог бүртгэгдсэн байдаг (Далантай, 2007) ба эдгээр овгууд нь өнөөгийн ар, өвөр монгол, ойрад халимаг, барга буриадыг багтаасан бүх монголчуудын эл овог элгэн, аймаг бүлгийн ихэнх хэсгийг нь хамарч байгаагаараа нэн их онцлог юм. Цахар монголчуудын овгийн бүрэлдэхүүний хамрах хүрээ хявцаа (хэмжээ) нь яг ийм өргөн дэлгэр байдаг болохоор тэдний зан үйлийн хэв шинж нь зохих талаар бүхий л эсгий туургат монголчуудын зан үйлийн өнгө төрх, им тэмдгийг тусган харуулсан байдаг.

Тиймээс харьцуулан судлах аргаар цахар хуримын аман яруу найргийн нийтлэг болон өвөрмөц зүйлсийг ар, өвөр монгол дахь цахар аймгийн хуримын аман яруу найргийн нийтлэг болон өвөрмөц зүйлстэй харьцуулан задалж, тухайн зан үйлийн дунд илэрсэн олон давхаргат эх сурвалжийг нээж, уг байдал, мөн чанарыг тодруулан гаргаж, түүний улмаас цахар хуримын уг сурвалж, үндсэн тогтолцоо, ялангуяа хувирч шинэчлэгдсэн ул мөрийг нь тодотгон тайлбарлах нь маш сонирхолтой бөгөөд чухал ач холбогдолтой асуудал болно.

### 1. Цахар нэрийн учир

Цахар бол Монголын их хааны харьяанд байсан олон отог бүхий том түмний нэр, мөн тус түмний доторх хааны шууд харьяанд захирагдах бүлэг хүмүүсийн нэрийдэл юм. Түүхэн судар тэмдэглэлүүдээс “Мин улсын судар” нь цахарын тухай он цагийн хувьд хамгийн эрт мэдээлжээ. Энд “Хойдын их хааны нэгэн аймаг ерөөс энэ хилд малжин суумуй. Өгүүлбээс даруй хуучин цахар хэмээмүй. Хишигтэн хэмээмүй, бурваг хэмээмүй, баруун хороогоо баруун гар хэмээмүй, зүүн хороогоо зүүн гар хэмээмүй” гэж цахарыг бүрдүүлж байсан таван отгийн нэрийг заан гаргасан боловч цахар хэмээх нэрийн утга холбогдлыг тайлбарласангүй байна. “Алтан товч”-д мэдээлснээр Жигаан ах Мандуухай хатныг ятгахдаа “Цахад хүнд эчхүл, цагаан морь татаж, цахар түмнийг эзэлье, цаглашгүй нэр алдаршью” (Qad-un ündüsün..., 2002: 273) хэмээн өгүүлсэн байдаг. Энд Таян хааныг “Цахад хүн” гэж, харьяа иргэдийг нь “Цахар” гэж нэрлэж байна. Цахад хүн хийгээд цахар иргэн нь бүр “Цах” язгуурын дор нэр үг үүсэх “р” дагавар залгаж “Цахар” гэх нэрийдэл буй болжээ.

Энэхүү “цахар” гэдэг нэрийн утгын талаар эрдэмтэд харилцан адилгүй олон таамаглал нотолгоо дэвшүүлдэг. О. Латтимор “цахар” хэмээх үгийг “Зах гэсэн үгээс үүсэлтэй бөгөөд хил хязгаар гэсэн утгатай” (Lattimore, 1958: 278) гэж үзсэн бол

Жамбажав зэрэг судлаачид “зах хар” гэсэн хатуу тушаал хүлээсэн цэргийн зохион байгуулалтаас улиран “цахар” гэдэг нэрийдлэг үүссэн гэж тайлбарлажээ. Цахар түмэн хил хязгаарт ойр суудгаас улбаалан зах гэсэн үгээс энэ нэрийг олсон гэж үзэх нь арай буруу болов уу. Яагаад гэвэл, цахар хэмээх нэр, хааны эл эзэмшил түмэн нь түүнийг нутгийн зах хязгаарт нутаглахаас нэлээд өмнө бүрэлдэн буй болж нэгэнт төлөвшөөд байжээ. “Эрдэнийн товч”-д “Цахар холбад отгийн одой эмгэн хэмээхийн охин хүүхнийг өлгөйдэн тавиад, Самар гүнж элэнцэг эхдээ одож” хэмээжээ. Дээрхээс үзвэл Эсэн хааны үед цахар түмэн үүсэн буй болоод байсан мэт. Тиймд дарийсун Хүдэн хаан нүүж нутгийн захаар нутаглах болсноос энэхүү нэрийг олсон хэмээх нь үнэмшил муутай болж байна.

Судлаач Учралт “Чингис хаанаас Тулуйд олгосон өмч иргэнийг Тулуйн хойчис цахар гэж нэрлэх болжээ гэж магадалж болох мэт” гэжээ. Энэ нь Тулуйн их хөвүүн Мөнх 1251 онд Монголын хаан ширээнд өргөмжлөгдсөнөөс хойш Лигдэн хааныг нас бартал энэ удмын хаад монголын төрийн дээд эрхийг атгаж байсан тул цахарыг хааны өмч эзэмшил гэсэн утгаар ийн үзэж болох мэт гэсэн санаа мөн. Энэ үзэлт нь Рамстедээс “Цахар гэгч ноёны ойр суусан улс” хэмээсэн үзэлттэй үндсэндээ адил байна.

Төмөрцэрэн авгай “Цахар гэгч үг түрэгийн олон хэл аялгуунд байдаг (хамгаалах, бэхлэх), перс хэлний цахар (үйлчлэгч, ажиллагч) гэдэг үг монгол хэлний цахар гэдэг үгтэй учир холбогдолтой хэмээн үзэх явдал нэлээд үндэстэй мэт санагдна” гээд “Шинжааны торгуудын аялгуунд цахар гэгч нь ноёд түшмэдийн дэргэд бараа бологч доорд хүмүүсийн гэр өргөө зэргийг нэрлэдэг байсан байна” (Төмөрцэрэн, 1961: 111–114) гэжээ.

## 2. Цахар монголчуудын гэрийн ерөөлийн онцлог

Цахар хуримын ёсонд охины талд хадаг сүй тавьснаас хойш хоёр тал хүү, хүүхний ураг хуримын бэлтгэлийг хийдэг бөгөөд хүүгийн талын бэлтгэл дотор гэр бүрэх нь нэг том ажил багтана.

**1) Хошлон, гэрийн бүс сураглаж авах ёсон.** Гэр бүрэх нь хүүгийн талын үүрэг байж, гэрийн модны зүйл; – хана, унь, тооно, хаалга; эсгийн зүйл; – дээвэр, туурга, үүд, ээмч, хаяавч, цаваг зэргийг хөвүүний тал хийдэг. Гэхдээ хүүхний тал бас хамжилцан гэрийн 22 хошлон, гэрийн дотор гадна 2 бүс, гэрийн өрхийг хүүхний тал хийдэг.

Гэр бүрэхээс гурван өдрийн өмнө хүүгийн аав нь архи тавагтай ирж хүүхний аав ээжээс нь хошлон, гэрийн бүсийг лавлан сурж аваачдаг. Энгийн хошлон нь дөрвөн судастай, тэнхээтэй айл нь зургаан судастай хийдэг. Энгийн гэрийн бүс нь найман судастай болдог, тэнхээтэй айл нь 10-12 судастай хийж үзүүрт нь цацаг гаргаж улаан хөх бөсөөр хээ гулз (угалз) гаргадаг. Хүүхний тал нь хошлон, гэрийн бүсээ өгөхдөө ойр орчмын нутгаа дуудаж архи идээгээр хошлон, гэрийн бүсээ мялааж ерөөл тавьдаг.

**2) Гэр бүрэх.** Гэр бүрэх гэдэг нь гэрийн мод, эсгий, хошлон, гэрийн бүс зэргийг нь тааруулах явдал байжээ. Өлзийтэй өдрийг сонгож ойр орчмын айл ба садан төрлөө дуудаж гэрээ бүрдэг. Үүнд хүүхний талыг дууддаггүй, тогтсон өдөр нь садан төрөл нь эсгий ноосны зүйл, эсгий оёх ээрсэн утас зэргийг сэлбэг болгон авчирдаг ажээ. Ингээд уужим, тэгш газарт бүрэх гэрийнхээ буурийг тогтоож, эрчүүд нь үдэж дарсан хана, ширдсэн хаалгаа авчран сонгосон буурь дээрээ босгож, гэрийн үүдийг

нь гал үд зүг хандуулан босгож, хол ойрын бараа харж өнгийвөр байх эсэх, хар нохойн ам тоссон эсэхийг шинжиж, ямар нэг сэжиггүй болбол униа зэтлэн тооноо гаргаж униа өлгөж гэрийнхээ модыг урьдаар босгодог. Тэгээд гэрийн боссон буюу хэвтсэн, ханын эрстэй буюу эрсгүй, унийн уртадсан буюу ахардсан, тоононы цомцгор буюу хэвтээ, үүд хаалганы өндөр эсэх зэргийг зүг бүхнээс нь шинжин ярилцаж засдаг. Эмэгтэйчүүд нь хоёр дээвэр, хоёр цаваг, дөрвөн туургыг гэрийн модны баргийг харан эсгэж, дутагдагсанд нь нэмж, илүүдсэнийг нь хайчлан авч залган оруулж, нэмэлтийг нь сайхан тааруулан оёж эхэлдэг. Дараа нь цавгийн найман хошлон, дарах туургын (хоёр туурга) найман хошлон, дарагдах хоёр туургын дөрвөн хошлон, хоёр дээврийн найман хошлонг бүрээсэнд нь шидэж оёдог. Ханын нийлцийг уях долоон хошлон буюу есөн хошлонг хар хөх орог ямааны ноосоор хийдэг учир гэрийн хошлонтой зүс нь нийлэхгүй, үүд, толговч, хаяавчийг хүүгийн ээж нь гэр бүрэхээс өмнө оёж бэлтгэдэг. Тогтовч, хаяавчид нь хошлон хэрэглэхгүй, ахар шидээс хэрэглэдэг. Үүдэнд хоёр хошлон хэрэглэдэг, өрхөнд дөрвөн хошлонг нийлүүлбэл зургаан ханатай гэрт 37 хошлон, найман тэрэмтэй гэрт 39 хошлон ордог.

**3) Өрх ерөөх** (гэр ерөөх ч гэдэг). Гэр бүрэх ажил бүтсэнээс хойш худ нь сарын сайн, өдрийн өлзийтэйг сонгож өрх ерөөх цагаа худгуйдаа хэлж өгдөг. Тогтсон цагтаа хүүхний аав ээж нь хэдэн хүнтэй, оёсон өрхөө архи тавагтай авч худдаа ирж өрхөнд нь дөрвөн хошлон шидэж, бүрсэн хангай цагаан гэрийнх нь тоонон дээр нь гаргаж зүүн баруун хойт гурван хошлонг нь батлан оёж өмнөх хошлонгоос нь татаж өрхийн өмнө хагасыг нь хойш нь хийж хариулдаг. Тэгээд тавгаа тавьж архийнхаа бөглөөг сугалан бурханд дээж тавин галд ба гадна цацаж, худ ба настан нарт архи барьснаас хоор гэр ерөөх үйл эхэлдэг. Хөвүүний аав нь хамгийн өндөр настанд архи барьж:

«Муу үрийн минь

Өрх нь өндийв

Үүд нь онгойв

Хүндэт та нарын

Өндийсөн өрхөд нь

Тонтойсон тотгод нь ерөөлөө хайрлахыг хүснэ» гэж мөргөхөд настан архийг нь авч өрхөөс нь хадаг буюу алчуур уяж тоононд нь архи буюу тос түрхээд:

«Түмэн өлзий бүтсэн

Төр улсыг бататгасан

Төгс их жаргалын түвшин сайн өнөөдөр

Найман талдаа унжсан

Наян хоёр оосортой

Ташаа нийлцийг нь тааруулсан

Далан хоёр оосортой

Өндөр газар барьсан

Өөхөн цагаан өргөө нь

Өлзий дэмбэрэлтэй болтугай!

Өрхөөс нь утаа хойголгүй

Үүднээс нь гийч хойголгүй

Хотноос нь мал хойголгүй

Хормойгоос нь ач нар хойголгүй

Нарлаг талд дунхайж

Насан туршдаа жаргатугай!» гэх мэтээр ерөөснөөс хойш бусад хүмүүс ч барьсан архийг нь авч өрхөөс нь хадаг, алчуур, мөнгө уях буюу морь, үхэр, хонь нэрлэн залгаа залгаагаар ерөөж гардаг.

**Тоононы ерөөл нь:**

– Яргай зандан цагирагтай, яшил зандан даагатай, хүдэр зандан хүрээтэй, алтан хорол голтой, арван эрдэнийн сийлбэртэй, зандан модыг залан хийсэн, зааны зоогоор үдэж хийсэн, сандан модыг сийлж хийсэн, сарлагийн зоогоор үдэж хийсэн, жаран дөрвөн хуруутай, зургаан салаа хэцтэй, наран сарны гэрэл цацарсан, найман өлзийн шинж бүрдсэн, эрхэм хоёр загас, элгээрээ нийлсэн, шүрэн улаан өнгөтэй, шүхэр эрдэнийн тооныг нь ерөөе!

**Унийн ерөөл нь:**

– Нялх харгайг залан хийсэн, наргүй сүүдэрт хатаан хийсэн, унага даагын дэл сүүлээр, оосор бүчийг нь томж хийсэн, адгүй тэгүхэн арзгаргүй шулуун, өндөр богино нь тэнцсэн, өргөн зузаан нь нийцсэн, үе зэрэгцэн жигдэрсэн, үлэмж гэрэлтэн цацарсан, унь эрдэнийг нь ерөөе!

**Хананы ерөөл нь:**

– Хар зандан модоор, ханыг нь чавчин хийсэн, хандгай бугын ширээр, эвхэж татан үдсэн, навчин бадмын эрээтэй, нарийн шижмийн оосортой, найман өнгийн зангиатай, найтаг бураа биетэй, азарга хөшүүрийн хүчээр, ай эвийг нь тааруулсан, асах галын нурмаар, арзгар биеийг нь гоолсон, өрөм шөвгийн дэмээр, өндийж боссон түүхтэй, үхэр царын үдээрээр, оршиж зогссон намтартай, тэрэм эрдэнийг нь ерөөе!

**Хаалганы ерөөл нь:**

– Баруун ууланд ургасан, бат цагаан занданг, баатар эрээр хэрчүүлж, банз татуулж үйлдэхдээ, ган сүхээр цавчуулж, галтай өрмөөр нүхэлж, харуулын ирээр өнгөлж, хасын өнгөөр гадарласан, эргэх хоёр далавчтай, эрдэнийн шүхэрийн шинжтэй, эвхэх ногоон бүслүүтэй, насны өлзий ивээлтэй, намсрай бурхан сийлээтэй, навч цэцгийн зурагтай, нар харсан гэгээвчтэй хаалга эрдэнийг нь ерөөе! Хамаг их буян хишиг, энэ гэрт орших болтугай!

**Өрхийн ерөөлд нь:**

– Усны доторх лянхуа шиг, удвал дэлгэрсэн шинжтэй, оюу эрдэнийн отог шиг, орны дээрээ гэрэлтэй, дэрэвсэн цагаан хун шиг, дээдсийн торгон хадаг шиг, талын цагаан мөөг шиг, тана сувдын мөхлөг, хур цасны халхавч, хурц нарны сэргээвч, түвшин амьдралын батлага, тэргүүн дээрх сүлд, энх цагаан сахиус, өрх чамайг ерөөе! Үүрдийн их буян хишиг, энэ гэрт орших болтугай... гэх мэтчилэн гэрийн багана, цах, тавиур, үхүг (авдар), тулга, галын хайчыг хүртэл бүх юмсыг үлдээж хоцроолгүй ерөөж сүү дусааж, тос түрхдэг юм. Гэрийн бүх ерөөл дүүрснээс хойш найр эхлэж, аав ээжийн дуу, ах бэргэний дуу, эгч хүргэн ахын дуу, дүү нарын дуу гэж үргэлжлэн, нэг өдрийн найр жаргал<sup>1</sup> болдог.

## ДҮГНЭЛТ

Дээр өгүүлсэн хэдэн жишээг хураангуйлан дүгнэж үзэхэд “Цахар” хэмээгч нь эхэндээ хааны ойр сууж, түүнд үйлчилдэг хүмүүсийг зааж байгаад хожим хааны шадар хамгаалагч, өмч иргэдийг нэрийдсэн утгатай болов уу хэмээн бид үзэж байна.

<sup>1</sup>Бүрэнжав, 1931 онд Шинжааны Боргал зуу (аймаг)-гийн Аршаан сияан (суман)-д төржээ, цахар ястан. 2012 оны 9 сарын 10- ны өдрийн сурвалжилга.

Ер нь монголчууд овог аймгаа гүйцэтгэх үүрэг, ажил мэргэжил болон удирдагчдын-хаа нэрээр нэрлэсэн явдал цөөнгүй байдаг. Халх түмний нэр нь халхлах, халхавч гэсэн үгээс үүсэтэй бол Чингис хааны дүү Хасар харвах намнахдаа гаргууд сайн байснаас түүний хувь иргэдийг хожим нь хорчин хэмээн нэрийдсэн. Ордос хэмээх нэр нь орд онгон гэсэн үгнээс улбаатайн нэгэн адил цахар хэмээх үг нь хааны ойр сууж түүнд үйлчилж байсан хүмүүсийг зааж байгаад 15-р зууны эхэн үеэс хааны эзэмшил түмний нэр болон хувирчээ. Бидний энэ үзэлтийн зөв болохыг цахарын үүсэл бүрэлдэл хийгээд түүхэн үүрэг, гавьяа зүтгэл нь мөн хажуу талаас батлан тодотгож байна.

Монголчуудын хуримлах ёсны зан үйлийг тусгасан яруу найраг түүний дотор ерөөлийн төрөл зүйл нь маш баян тансаг байдгаас цахар хуримын зан үйлд шууд нөлөөлсөн байна. Үүний бодит илрэл нь цахар хуримын ерөөлийн төрөл зүйл, ерөөл тавих зан үйл, ерөөлийн бүтэц, уран сайхан үг хэллэгээр батлагдаж байна.

Монгол хуримын зан үйл хөгжлийн урт замыг туулахдаа анхны учир утга, үүрэг зориулалтаа алдаж зөвхөн ёслолын шинжийг олох, тухайн үеийн нөхцөл шалтгаанаар шинэ шинэ элемент, төрөл зүйлээр баяжих зэргээр ихээхэн хувьсан өөрчлөгдөж байна. Иймээс монгол соёлын зан үйлийн бүрэн бүтэн цуглалан, нийлбэр, цогцолбор болсон хуримын зан үйлийг анхааралтай судалж, өнөөгийн амьдралд нийцэх ашиг тустай дэвшилттэй ёс заншлыг сурталчлах, дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад бага балчраас нь эзэмшүүлэх арга ухааныг шинэ нөхцөлд тохируулан боловсруулах, цаашид зөв голдирлоор нь хөгжүүлэх шаардлагатай байна.

## Ашигласан материал

- Далантай, Балдан (2007). *Цахар монголын зан үйл*. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.  
*Монголын нүүдэлчдийн соёл: оршихуй, эс оршихуй* (1998). Редактор Сумьяа, Б. Улаанбаатар: Адмон хэвлэлийн газар.
- Төмөрцэрэн, Ж. (1961). Цахар хэмээх үгийн учир. *SM (Монгол судлалын зарим асуудал)*. III. 1. Улаанбаатар. 107–115.
- Цахар ардын ерөөл магтаалын чуулган* (2014). Ц. Гэрэлбаатар, Ш. Хишигманлай нар эмхэтгэн найруулав. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
- Lattimore, Owen (1935/1958). *The Mongols of Manchuria*. London: GEORGE ALLEN & UNWIN LTD. *Манжуурын монголчууд*. Шанхай.
- Qad-un ündüsün quriyangyui Altan tobci: эх бичгийн судалгаа* (2002). Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Шаравын Чоймаа; эрхлэн нийтлүүлсэн Ц. Шагдарсүрэн. Улаанбаатар.

## References

- Dalantai, Baldan (2007). *Tsaxhar mongolyn zan uyil*. People's Press Committee of Inner Mongolia (in Mongolian).
- Mongolian Nomadic Culture: Presence or Absence* (1998). Editor Soumya, B. Ulaanbaatar: Admon Publishing House (in Mongolian).

Timurceren, J. (1961). The reason for the word Tzahar. *SM (Some Issues in Mongolian Studies)*. III. 1. Ulaanbaatar. 107–115 (in Mongolian).

*Tsakhar ardyn erool magtaalyn chuulgan* (2014). Ts. Gerelbaatar, Sh. Khishigmanlai nar emkhetgen nairuulav. People's Press Committee of Inner Mongolia (in Mongolian).

Lattimore, Owen (1935/1958). *The Mongols of Manchuria*. London: GEORGE ALLEN & UNWIN LTD. *The Mongolians of Manchuria*. Shanghai (in English).

*Qad-un ündüsün quriyangyui Altan tobči: a study of the original text* (2002). Sharavyn Choimaa, who did transliteration, word chaining, and original manuscript research; published by T. Shagdarsuren. Ulaanbaatar (in Mongolian).